БАТЛАВ

ХОТЫН СТАНДАРТ, ХЯНАЛТЫН ГАЗРЫН ДАРГА

С.ТӨМӨРДУЛАМ

2022 оны 09 дугаар сарын 22

СУУРЬ СУДАЛГАА ХИЙХ АЖЛЫН ДААЛГАВАР

2022 оны 09 дугаар сарын 22 Улаанбаатар хот

ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Баримт бичгийн нэр:	Агаарын чанарын стандартын суурь судалгаа
Ажил гүйцэтгэх хугацаа:	Хуанлийн 60 хоног

ҮНДЭСЛЭЛ:

Хотын стандартын удирдамж, арга зүйн баримт бичиг боловсруулах ажил нь Монгол Улсын хууль тогтоомжид нийцэх бөгөөд дараах баримт бичгүүдэд тусгасан зорилго, зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээний бүрэлдэхүүн хэсэг болно. Үүнд:

- Улсын Их Хурлын 2016 оны 19 дүгээр тогтоолоор баталсан "Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал 2030";
- Засгийн газрын 2016 оны 344 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралт "Үндэсний чанарын хөтөлбөр";
- Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл;
- Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр;
- Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 6.1.5 дахь заалт "Хотын стандарт, норм, дүрмийг олон улсын жишигт нийцүүлэн боловсруулж, мөрдүүлэх ажлыг үе шаттай хэрэгжүүлнэ." зэрэг хөтөлбөрт туссан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд чиглэсэн стандарт, норм дүрэм болон хэрэгжилт, өнөөгийн байдлын суурь судалгаа хийх шаардлагатай болсон.

ЗОРИЛГО:

Урт хугацааны бодлогын баримт бичиг болон үйл ажиллагааны хөтөлбөрт туссан арга хэмжээний хэрэгжилтийг хангах, эрүүл аюулгүй орчин бүрдүүлэх, хотын стандартыг олон улсын жишигт нийцүүлэн боловсруулах зорилгоор холбогдох сэдвийн хүрээнд суурь судалгаа хийх зөвлөх үйлчилгээ үзүүлэхэд энэхүү ажлын даалгаврын зорилго оршино.

ХАМРАХ ХҮРЭЭ:

Монгол Улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа агаарын чанартай холбоотой стандартуудыг судалж, үнэлэлт, дүгнэлт өгөх, шинээр болон шинэчлэн боловсруулах шаардлагатай стандарт болон түүний хэрэгцээ, шаардлагыг тодорхойлох. Зөвлөх баг нь

шаардлагатай гэж үзвэл судалгааны хамрах хүрээг өөрчлөх талаар захиалагч талтай зөвшилцөн хамтын шийдвэрээр өөрчлөлт оруулж болно.

СУДАЛГААНЫ ХҮРЭЭНД ХИЙГДЭХ АЖЛУУД:

Судалгааны тайланд дараах агуулгыг тусгасан байна. Үүнд:

Д/д	Агуулгын нэр	Агуулгын хүрээнд шаардлагатай мэдээлэл
1	Хамрах хүрээ	Тухайн судалгааны ажлыг гүйцэтгэн дүн шинжилгээ хийхэд хамгийн тохиромжтой, үр нөлөөтэй байхаар тодорхойлсон байна.
2	Өнөөгийн байдал	-Өмнөх судалгааны материалыг судлах; -Агаарын чанарын стандартын хэрэгжилт, үр дүн -Практикт гарч буй асуудал, түүнийг тоо баримтаар баталгаажуулах;
3	Судалгааны аргачлал	Судалгааг ямар арга зүй, аргачлалыг ашиглан, судалгааны үе шатыг хэрхэн зохион байгуулж, дүн шинжилгээ хийсэн үйл явцын талаарх мэдээллийг агуулсан байх;
4	Судалгааны үр дүн	-Судалгаа хийснээр хүрсэн үр дүнг тодорхойлох; -Гадаад орны туршлага судлан өөрийн оронд нутагшуулж болох шинэлэг санааг тусгасан байх; -Судалгаа хийсэн объектын байршлыг газарзүйн мэдээллийн системийн программ хангамжид бүртгэх /ArcGIS/
5	Судалгааны дүгнэлт	-Судалгааны ажлын үр дүнгийн талаар тодорхой үнэлгээ өгсөн байх; -Агаарын чанарын стандартын хэрэгцээ, шаардлагыг тодорхойлж, үнэлэлт, дүгнэлт өгсөн мэдээллийг багтаасан байх; -Шинжлэх ухааны болон практик талын ач холбогдлыг тусгасан байх;
6	Ашигласан материалын жагсаалт	Судалгааны ажилд ашиглагдсан материалуудыг зохих стандартын дагуу бичиж тэмдэглэсэн байна.

Судалгааны ажлыг дараах чиглэлийн дагуу зохион байгуулна. Үүнд:

1. Судалгааны үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулж, захиалагч байгууллагаас санал авч батлуулах;
2. Судалгааг зохион байгуулж явуулах арга зүй болон удирдамжийг боловсруулах, батлуулах;
3. Судалгааны явцад эх сурвалжийг тогтмол бүрдүүлэх;
4. Судалгааны анхдагч материалуудыг баримтжуулах;
5. Судалгаанд цуглуулсан мэдээллийг боловсруулж, нэгдсэн үр дүнгийн тайлан, санал зөвлөмжийг боловсруулж төсөл хэрэгжих хугацааны хуваарийн дагуу захиалагчид танилцуулах, ирүүлэх, хүлээлгэн өгөх;
6. Бусад шаардлагатай үйл ажиллагааг хэрэгжүүлэх.

ЗӨВЛӨХӨД ТАВИГДАХ ШААРДЛАГА:

Зөвлөх нь дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

- Зөвлөх нь Монгол улсад бүртгэлтэй судалгааны чиглэлээр үйл ажиллгаа явуулдаг хуулийн этгээд, аж ахуйн нэгж, мэргэжлийн холбоо, төрийн бус байгууллага байх
- Судалгаа, шижилгээ хийж байсан туршлагатай байх;

Зөвлөх үйлчилгээг гүйцэтгэгч нь дараах шаардлагыг хангасан 4-өөс доошгүй гишүүнтэй хуулийн этгээд байна. Үүнд:

Мэргэжил:

- *Багийн ахлагч:* Тухайн чиглэлээр мэргэшсэн инженер эсхүл магистр болон түүнээс дээш эрдмийн цол зэрэгтэй байх;
- *Багийн гишүүд:* Байгалийн шинжлэх ухаан, эх газар судлал, багш байгалийн ухааны боловсрол, экологи, хүрээлэн буй орчны шинжлэх ухаан, хүрээлэн буй орчныг хамгаалах технологи, байгаль орчны зайнаас тандан судлал, эрх зүй, статистик, гадаад хэлний орчуулга, хэл шинжлэлийн мэргэжлээр бакалавр ба түүнээс дээш зэрэгтэй байх.

Туршлага:

- Багийн ахлагч: Мэргэжлээрээ судалгааны баг удирдаж, зөвлөх үйлчилгээ үзүүлж байсан туршлагатай байх;
- Багийн гишүүд: Мэргэжлээрээ ажилласан туршлгатай байх.
- Судалгаа шинжилгээний болон бодлогын баримт бичиг, стандарт боловсруулах арга зүй, ур чадвар, дадлага, туршлагатай байх;
- Судалгаа, шинжилгээний материалтай танилцаж, үнэлэлт дүгнэлт хийх чадвартай байх
- Тухайн сэдвийн хүрээнд гадаад улс, олон улсын туршлагыг судлах зохих шатны мэдлэгтэй байх;
- ArcGIS программ дээр ажилладаг байх;

АЖИЛ ТАЙЛАГНАХ ҮЕ ШАТНЫ ХУВААРЬ:

Судалгааны ажил нь дараах үе шаттай байна. Үүнд:

Д/д	Ажлын үе шат	Хугацаа (60 хоног)	Тайлбар
1	Судалгааны ажлын эхний тайланг	Зөвлөх үйлчилгээний ажил эхэлснээс хойш 30 хоногийн дотор	Монгол Улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа агаарын чанартай холбоотой стандартуудыг судлах, шинээр боловсруулах хэрэгцээ шаардлага болон Улаанбаатар хоттой ижил нөхцөлтэй гадаад улсын жишээ, манай нөхцөлд тохирох шинэ туршлага нэвтрүүлэх, олон улсын стандартыг нутагшуулах зэрэг санал дэвшүүлэн харьцуулсан мэдээлэл бүхий суурь судалгааг захиалагчид танилцуулах;

2	Тайланг эцэслэн хүлээлгэн өгөх	Судалгааны ажлыг бүрэн дуусгасан эцсийн тайланг эхний тайланг танилцуулснаас хойш 30 хоногийн дотор захиалагчид хүргүүлж хүлээлгэн өгөх	Захиалагчийн өгсөн санал, шүүмжийг тусган одоогийн байдалд үнэлэлт дүгнэлт хийж, тайланг эцэслэн хүлээлгэн өгөх;

ОНЦГОЙ НӨХЦӨЛ

Судалгааны ажлын хүрээнд цуглуулсан мэдээлэл, судалгааны үр дүн, тайлан, баримт бичиг нь “Зохиогчийн эрхийн тухай хууль”-ийн дагуу Хотын стандарт, хяналтын газрын өмч болно.

ХЯНАСАН:
БАЙГАЛЬ ОРЧНЫ СТАНДАРТЫН ХЭЛТСИЙН ДАРГА Д.ӨЛЗИЙСАЙХАН

БОЛОВСРУУЛСАН:
МЭРГЭЖИЛТЭН Д.НОМИН